



УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН СТАНДАРТ

---

УС ТҮГЭЭХ БАЙРНЫ УС ТҮГЭЭГЧИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ШААРДЛАГА


CS 11-0333: 2015



Улаанбаатар хот  
2015 он

## БАЙГУУЛЛАГЫН СТАНДАРТ

Ус түгээх байрны ус түгээгчийн үйлчилгээнд тавих шаардлага	<b>CS 11-0333 :2015</b>
Service requirements for water distribution kiosk operator	



Ус сувгийн удирдах газрын даргын 2015 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/113 дугаар тушаалаар батлав.

### 1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь “Ус сувгийн удирдах газар”-ын харьяа төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн системээс хангагдаж байгаа ус түгээх байрны ус түгээгч нь үйлчлүүлэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээнд соёлтой, боловсон харьцааг мэдрүүлж, тэднийг инээмсэглэж угтаад, инээмсэглэн үддэг, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, байгууллагын үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд оршино.

2. Энэхүү стандартыг Ус түгээх байрны /УТБ/ үндсэн болон гэрээт ус түгээгчид дагаж мөрдөнө.

### 3. Норматив ишлэл

Энэ стандартад MNS5775:2014 Монгол улсын стандартаас ишлэл хийсэн бөгөөд тэдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн албан ёсны эх материалыг ишлэл болгоно.

4. Нэр томъёо, тодорхойлолт: Энэхүү стандартад орсон зарим нэр томъёог дараах байдлаар ойлгоно.

4.1 “Төвлөрсөн ус хангамж” гэж ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглан хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйл ажиллагаа

4.2 “Төвлөрсөн бус ус хангамж” гэж гүний худгаас болон төвлөрсөн шугаманд холбогдсон ус түгээх байрнаас усыг зөөвөрлөн түгээж, хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйл ажиллагаа

4.3 Ус Түгээх Байрны “Ус түгээгч” гэж үйлчлүүлэгчдийг стандартад тохирсон цэвэр усаар хангах үйлчилгээг үзүүлж буй ажилтан

5. Ус түгээх байрны ус түгээгч нь ажлын байранд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

- 5.1 Ус түгээгч нь байгууллагын нэрийн өмнөөс хэрэглэгчдэд үйлчилж байгаагаа ямагт ухамсарлаж, хэрэглэгчээ дээдлэн байгууллагын нэр хүндийг эрхэмлэх;
- 5.2 Ус түгээгч нь ажил эхлэхээс 10 минутын өмнө ирж, өөрийн ажлын байр техник хэрэгслийн бэлэн байдал бүрэн хангаж, хэрэглэгчдэд үйлчлэхэд бэлэн байх;
- 5.3 Ус түгээгч нь ажлын байранд Монгол улсын стандарт MNS 5775:2014-ийг мөрдөн ажиллах
- 5.4 Ус түгээгч нь жилд 2 удаа эрүүл мэндийн үзлэгт орсон байх бөгөөд шинжилгээний дэвтэрээ ажлын байранд тогтмол байлгах;
- 5.5 Ус түгээгч нь байгууллагын сургалтын төвийн сургалтанд хамрагдаж “Чадамжийн гэрчилгээ” авсан байх;
- 5.6 Усны чанарын шинжилгээний бичиг, тоолуурын баталгаажилтын гэрчилгээг ил харагдахуйц байрлалд байршуулах;
- 5.7 Ус түгээгч нь байгууллагаас батлагдсан үнэ тарифаар үйлчлэх;
- 5.8 Ус түгээгч нь байгууллагаас батлагдсан УТБ-ны ажиллах цагийн хуваарийг чанд сахин мөрдөх;
- 5.9 Байгууллагын дүрэмт хувцас /халат/ өмсөж, энгэрийн тэмдгийг цээжний зүүн дээд хэсэгт харагдахаар тэгш зүүсэн байх;
- 5.10 Үйлчлүүлэгчийг “Та сайн байна уу?” гэсэн мэндчилгээгээр угтан авч үйлчилгээг үзүүлсний дараа “Баярлалаа, Баяртай” гэсэн үгээр үдэх;
- 5.11 Ус түгээгч нь үйлчлүүлэгчтэй харилцахдаа өөр тийшээ харах, анзаараагүй сонсоогүй дүр эсгэх, удаан хүлээлгэх, загнах, доромжлохгүй байх;
- 5.12 Үйлчлүүлэгчийн зүгээс гарч болох тааламжгүй харилцаанд ямар ч тохиолдолд эелдэг түвшин байдалтай байж, сэтгэл хөдлөлийн огцом өөрчлөлтүүдийг илэрхийлэхгүй байх;
- 5.13 Үйлчлүүлэгчийн өөдөөс эгцлэн харж хүндэтгэлийн үг хэллэгийг тухайн нөхцөл байдалд тохируулан сонсогдохоор тод хэрэглэж харилцах;
- 5.14 Ус түгээгч нь ажлын байранд гадны хүн оруулах болон өөрийн оронд ажиллуулахыг хориглоно;
- 5.15 Хэрэв гэрээт УТБ бол хоёр ус түгээгчтэй давхар гэрээг хийж, эрүүл мэндийн үзлэгт орсон байх шаардлагатай

6. Хяналт, хариуцлага, урамшуулал

6.1 Стандартын хэрэгжилтийн өдөр тутмын хяналтыг хэсгийн ахлагч, салбарын техникч, инженер, явцын хяналтыг албаны инженер, дарга, ерөнхий хяналтыг Хэрэглэгчийн үйлчилгээ, гэрээ мониторингийн хэлтэс тавьж ажиллана;

6.2 Стандартыг зөрчсөн тохиолдолд байгууллагын дүрэм, дотоод журамд зааснаар сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно;

6.3 Үйлчилгээний стандартыг мөрдөж, идэвхи санаачлагатай ажиллан үйлчлүүлэгчдээс удаа дараа талархал хүлээсэн ус түгээгчийг холбогдох журмын дагуу шагнаж урамшуулах болно;

7. Техникийн шаардлага

7.1 Стандартын шаардлага хангасан барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжтэй байх;

8. Аюулгүй ажиллагааны шаардлага

8.1 Ажлын байрны аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахин ажиллах;

8.2 Ажлын байрны цахилгаан болон галын аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах;

8.3 Цахилгааны гэмтэл гарсан тохиолдолд шуурхай мэдэгдэж засварлуулсан байх;

Төгсөв.